

БНХАУ-ЫН СИНЬЦЗЯН УЙГУРЫН ӨӨРТӨӨ ЗАСАХ ОРНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

*Н.Ариунгуа**

Синьцзян Уйгурын Өөртөө Засах Орон /СҮӨЗО/ нь БНХАУ-ын үндэсний цөөнхийн хамгийн асуудалтай районуудын нэг бөгөөд Синьцзяны нийгэм, улс төрийн тогтвортой байдал нь БНХАУ-ын цаашдын хөгжилд маш чухал ач холбогдолтой юм. Учир нь Синьцзян нь Хятадын хувьд Төв болон Өмнөд Ази руу гарах гол гарц болохоос гадна Синьцзян дахь олон төрлийн эрдэс баялаг /түүн дотроо газрын тос, уран/ цөмийн болон пуужингийн байршил нь Хятадын их гүрний сүр хүчийг илэрхийлдэг.

СҮӨЗО нь Хятад улсын баруун хойт хязгаарт байрладаг ба зүүн талаараа Хятадын Ганьсу, Цинхай /Хөх нуур/ мужуудтай, зүүн хойт хэсгээрээ Монгол Улстай, хойт талаараа ОХУ-тай, баруун хойт хэсгээрээ Казахстан, баруунтаа Киргизстан, Тажикстан болон Афганистантай, баруун өмнөд хэсгээрээ Пакистантай тус тус хиллэдэг ба урдуураа Кунлуний нуруугаар Төвдөөс тусгаарлагддаг ажээ. Ийнхүү Синьцзян нь Төв Азид оршдогийн хувьд тус бүс нутаг дахь Хятадын оролцоог зайлшгүй болгож өгч байгаа юм.

Төв Азид өрнөж буй интеграцчлалын үйл явц нөгөө талаас бүс нутагт оршиж буй терроризмын аюул занал, салан тусгаарлах хөдөлгөөн, хар тамхины наймаа зэрэг нь тус бүс нутагт оршдог СҮӨЗО-д бүрэн хамааралтай учир СҮӨЗО-ы гадаад, дотоод улс төрийн нөхцөл байдал түүнтэй хил залгаа Монгол Улсын хувьд анхаарал татахуйц чухал асуудлуудын нэг болж байна.

СҮӨЗО-ы нэг онцлог бол уугуул үндэстнүүд нь хан /хятад/ үндэстэнтэй харьцуулах юм бол тооны хувьд давамгайлж байдаг Хятадын цорын ганц цөөнх үндэстний район юм. /ӨМӨЗО, ТӨЗО зэрэгт хятад үндэстэн давамгайлж байдаг/

Синьцзяны хүн амын ихэнхи хэсгийг бүрдүүлдэг исламын бүлэглэлүүд нь өөртөө засах эрхээ өргөжүүлэхийн төлөө байдаг ба Синьцзяны радикал хүчнүүд нь зэвсэгт тэмцэл хийхийн зэрэгцээ террорист үйл ажиллагаагаа хэрэгжүүлсээр ирсэн билээ. Өөрөөр хэлбэл салан тусгаарлах хөдөлгөөн нэлээд хүчтэй өрнөж буй район юм. Иймээс СҮӨЗО нь БНХАУ-ын тогтвортой хөгжил, үндэсний аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд нэлээд саад тотгор учруулж болохуйц хүчин зүйл юм.

*Н.Ариунгуа - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

СҮӨЗО-ны талаархи Хятадын Засгийн газрын бодлого нь нэлээд зөрчилтэй байж багагүй ч бэрхшээлтэй тулгарч ирсэн билээ.

90-ээд оноос Төв Азид исламын хэт даврагсад /ваххабистууд/ үйл ажиллагаагаа идэвхжүүлснээр тус бүс нутагт аюулгүй байдлын шинэ системийг бүрэлдүүлэх шаардлага гарч хэт даврагсад болон салан тусгаарлагчдын эсрэг олон улсын хэмжээнд нэгдэх хандлага бий болсон билээ. Иймээс 1996 онд Хятад улс “Шанхайн 5” гэсэн олон улсын байгууллагад нэгдэн орсон нь эхлээд орон нутгийн хэмжээнд хил болон хилийн орчмын бүс нутгийн амгалан байдлыг хангах, хууль бус наймаа эрхлэгчдийн эсрэг тэмцэх зорилготой байсан боловч цаашид энэхүү байгууллагын үйл ажиллагаа нь тэлж өргөжин олон талын салбарыг хамрах хандлагатай болов.

АНУ-д болсон 2001 оны 9-р сарын 11-ний үйл явдлаас хойш тус өөртөө засах нутгийн талаархи Хятадын бодлогод анхаарал татахуйц шинэ зүйл бий болсон юм. Хэрэв дээрхи үйл явдлаас өмнө Хятад улс Синыцзяны салан тусгаарлах хөдөлгөөнийг зөвхөн Хятадын дотоод улс төрийн үйл явдал хэмээн үзэж байсан бол энэ цаг үеэс эхлэн олон улсын терроризмын салшгүй нэг хэсэг хэмээн хүлээн зөвшөөрсөн юм.

Сүүлийн үед Хятад улс терроризмын эсрэг үйл ажиллагаагаа эрчимжүүлж тус үйл ажиллагаандаа армийг татан оролцуулах, 2 жилийн турш терроризмын эсрэг тэмцлийн онолыг судлах, хамгаалах, аврах, дайрах гэсэн 3 үндсэн зорилтыг дэвшүүлэх зэрэг олон төрлийн арга хэмжээ авч байгаа бөгөөд Синыцзянаас гадна Төвд, ӨМӨЗО зэрэг цөөнх үндэстний районд байнгын үйл ажиллагаатай зэвсэгт хүчин илгээсэн байна.¹ Чингэхдээ Хятад улс алан хядагчдын үйл ажиллагааг үндэстний болон шашны хөдөлгөөнтэй хольж хутгаж болохгүй гэж үзэж байна.

Хятадын Засгийн газрын анхаарлын төвд байдаг энэхүү өөртөө засах орон нь уйгур үндэстэн голлосон үндэстний цөөнхийн нутаг юм. Өнөөгийн байдлаар уйгур үндэстнээс гадна тус районд казах, хотон, киргиз, монгол үндэстэн аж төрдөг ба тэдгээр нь 5 тойрог, 6 өөртөө засах муж болон 43 үндэстний тосгонд тус тус хамаарагддаг байна.

Синыцзян дахь монголчууд нь Чингис хааны үед анх Синыцзянд нэвтрэн орж, хожим нь Чагадайн улс, Зүүн Чагадайн улсад харьяалагдах чухар аймгууд Синыцзянд очиж суурьшсан ба Манж Чин улсын үед Зүүн гарын торгууд Хятадад дагаар орсноор тэнд суурьшин амьдрах болжээ. Тэдгээр нь Баянгол, Борталын монгол үндэстний автономит тойргууд Или, Тачэн, Алтайн тойргууд болон Урумчи, Карамай хотуудад тус тус аж төрөх бөгөөд 1998 оны байдлаар хүн амын тоо нь 159.1 мянга байв.²

Синыцзяны уйгур, казах, хотон үндэстнүүд исламын шашинтан бөгөөд Синыцзяны мусульманчуудын ихэнхи нь сунитын урсгалыг

дагадаг байна. Түүнээс гадна шиит, суфитын урсгал, халифатын сургаал болон том имамын урсгал ч байдаг байна. Тэдгээр нь харилцан маш их зөрчилтэй оршин тогтнож иржээ.³ Харин одоогийн байдлаар Хятадын албан ёсны мэдээгээр тэдгээрийн хооронд ноцтой зөрчил байхгүй ажээ. СҮӨЗО-ы 10 үндэстний 8 сая хүн өөрөөр хэлбэл хүн амын 50% нь исламын шашин шүтдэг ба 79 исламын нийгэмлэг, 20010 сүм хийд болон 3927 мөргөлийн бага хэмжээний газрууд байдаг байна.

Синьцзян дахь исламын дараах том шашин бол буддизм юм. ХХ зууны 50-иад онуудад Синьцзянд буддын 129 сүм хийд, дацан байснаас 98 нь шарын шашны, 30 нь Хятадаас гаралтай буддизмын сүм хийд байжээ. Гэвч “соёлын хувьсгалын” үеэр буддын шашны сүм хийдийг түйвээж шашин шүтэхийг хорьсон юм. Харин 80-аад оноос эхлэн Хятадад шашин шүтэх явдлыг чөлөөтэй болгосноор Синьцзянд ч гэсэн буддын сүм хийдүүд үйл ажиллагаагаа сэргээж эхэлсэн бөгөөд өнөөдөр 51 буддын сүм байгаагаас 40 нь шарын шашных, 11 нь хятадаас гаралтай буддизмынх ажээ. Харин лам хуврагын тоо нэг их биш бөгөөд зөвхөн 304 лам байдаг ба тэдгээрээс 296 нь шарын шашны лам байхад зөвхөн найм нь буддистууд байх жишээтэй.⁴

1983 онд СҮӨЗО-ы буддистуудын холбоо шүтлэгтнүүд ихээр бөөгнөрөн амьдардаг Урумчи, Баянгол, Борталын Монгол автономит тойргууд болон Цзинсянь, Шосянь мужид тус тус байгуулагдсан байна.

СҮӨЗО нь Хятадын нэлээд хоцрогдсон баруун хойт бүст байрладаг ба эдийн засгийн хувьд хөгжлөөр дорой Хятадын цөөнх үндэстний район юм.

1999 онд Хятадын засгийн газраас баруун хойт бүс нутгийг эрчимтэй хөгжүүлэх стратеги боловсруулснаар Синьцзянд хөгжлийн шинэ боломж нээгдсэн юм. 10-р таван жилийн болон 2010 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөөний дагуу 2005 он гэхэд тус автономит районы дотоодын нийт бүтээгдэхүүн нь 210 тэрбум юаньд хүрэх ба жилийн өсөлт нь 9%, ДНБ-ний нэг хүнд ногдох дундаж 10.000 гаруй юаньд тус тус хүрэх ажээ. Нийгмийн салбарт оруулах хөрөнгө оруулалт 420 тэрбум юань, хот газрын хүмүүсийн дундаж орлого 7%, хөдөө тосгонд 150 юаниар өсөх ажээ. Нэг хүнд ногдох орон сууцны талбай 23 км² хүрэхээс гадна чанар нь сайжирч эрүүл ахуйн хувьд баталгаатай болгох ажээ.⁵

Хятадын засгийн газраас СҮӨЗО-нд санхүүгийн тэтгэлэг олгодог бөгөөд тэр нь 90-ээд оноос эхлэн өссөөр иржээ. Тухайлбал, 1996 он 5.91 тэрбум юань, 1997 онд 6.84 тэрбум юань, 1998 онд 8.01 тэрбум юань, 1999 онд 9.4 тэрбум юань, 2000 онд 11.9 тэрбум юань, 2001 онд 13.38 тэрбум юань байх жишээтэй. 2001 оноос эхлэн Дэлхийн Банкны 22 төсөлд хамаарагдан 1.798.95 сая ам.долларын буюу

өнөөгийн ханшаар 14.931.28 сая юаний зээл авсан байна. Мөн Канад болон бусад гадаадын орноос авсан 410.67 сая ам.долларын зээлээр 68 төсөл хэрэгжиж байна.

Хятадын засгийн газраас оруулж буй хөрөнгө оруулалт нь гол төлөв газрын тос, байгалийн хий олборлох салбарт ноогдож байгаа бөгөөд тэрхүү хөрөнгө оруулалт нь жилээс жилд өссөөр иржээ. Тухайлбал, 1995 онд 18.2 тэрбум юань байсан бол 2000 онд 29.22 тэрбум юань хүртлээ нэмэгджээ. Нөгөөтэйгүүр 120 тэрбум юань зүүнээс баруун чиглэлийн байгалийн хийн хоолой байгуулах төсөлд зарцуулагдахаар төлөвлөгдөж байгаа ба энэхүү ажил нэгэнт эхлээд байгаа юм.

Синьцзянд нефть, байгалийн хий олборлолтын салбар хөгжихийн сацуу түүнийг дагалдан мөн машины үйлдвэрлэл, тээвэр, холбоо харилцаа, барилга, цахилгаан эрчим хүч, хүнс, нэхмэл, хими, хуванцар, резин, эмийн үйлдвэрүүд болон хөдөө аж ахуйн салбар мөн хөгжих хандлагатай болсноос гадна үйлчилгээний салбар, худалдаа хурдацтай хөгжиж тус өөртөө засах орны эдийн засгийн бүтцийн хөгжилд сайнаар нөлөөлсөн байна. Мөн ажлын байрны тоо ч нэмэгдэж байна. Тухайлбал 1994 оноос Таримын хөндийн газрын тосыг олборлож эхэлснээр Баянголын монгол үндэстний автономит тойргийн ажлын байр 18% нэмэгдсэн байх жишээтэй. Үүнээс гадна хотжилтын үйл явц түргэсч газрын тос үйлдвэрлэж буй нутгуудад шинэ шинэ хотууд бий болсон нь Карамай Душанцзы /Майтаг/ Фудун, Цзэпу зэрэг хотууд бөгөөд тэдгээрийн үүсэл нь орон нутгийн эдийн засгийн хөгжилд сайнаар нөлөөлөв. Карамай, Туха, Тарим болон Цзэпу, Душанцзы, Урумчи, Карамайн нефтийн том үйлдвэрүүд нь орон нутгийн эдийн засгийн хөгжилд хөрөнгө оруулалт хийж байна. Тухайлбал, Таклимахань цөлийг гаталж буй хойт зүгээс өмнө зүг рүү чиглэх хурдны замыг тавих ажил Таримын газрын тосны үйлдвэрийн 785 сая юаний хөрөнгө оруулалтаар байгуулагдаж байна. Өөрөөр хэлбэл газрын тос, байгалийн хий, нефть-химийн үйлдвэрлэл нь СУӨЗО-ы орлогыг их хэмжээгээр нэмэгдүүлж байна. Зүүнээс баруун зүгт чиглэх байгалийн хийн хоолой байгуулах төсөл гэхэд л Синьцзяны жилийн орлогыг 1 тэрбум юаниар нэмэгдүүлэх жишээтэй.

Ер нь Синьцзян эрдэс баялгаар баян баруун бүс нутагт хамаарагддаг ба энэ утгаараа хүнд үйлдвэрийг хөгжүүлэх гол газруудын нэг юм. Синьцзян Уйгурын Өөртөө Засах Орны Жунгар, Турфан, Хами, Цайдам, Сычуаны хөндий нь газрын тос, байгалийн хийн нөөцөөр баялагаас гадна нүүрсний нөөцөөр улсдаа тэргүүлдэг юм.

Хятадын засгийн газраас Синьцзяны эдийн засгийг хөгжүүлэхэд онцгой анхаарал хандуулж байгаа бөгөөд энэхүү бодлого нь Хятадын

баруун бүс нутгийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний хүрээнд хэрэгжиж байгаа болно. Тус төлөвлөгөөний дагуу хязгаар нутагт нээлттэй бодлого хэрэгжүүлэх стратегийн шинж чанартай хууль дүрмийг бий болгох, Синьцзян зэрэг баруун бүс нутгийг гадаадад улам нээлттэй болгоход 8 зүйлийн давуу эрх, хөнгөлөлт үзүүлэх бодлого хэрэгжих юм.

Хятадын засгийн газраас Синьцзяныг үр тариа, бөс барааны үйлдвэрлэлийн бааз суурь болгох, “3 хойт” /зүүн хойт, баруун хойт, хойт нутгууд/ гэсэн төлөвлөгөөний дагуу ой модоо цөлжилтөөс хамгаалах, ядуу районуудын эдийн засгийг хөгжүүлэхэд хөнгөлөлт үзүүлэх, хил хязгаар нутагт засмал зам байгуулах, хилийн боомтуудын засмал замыг сайжруулах, Тарим голын экологийг сайжруулах, усны нөөцийг иж бүрнээр ашиглан хамгаалахад чиглэгдсэн дэд бүтцийг байгуулахад СУӨЗО-д давамгайл эрх олгох, үүнд төвийн төсвөөс хөрөнгөө гаргах, улсаас олгох зээл, олон улсын санхүүгийн байгууллага болон гадаад орноос авч буй зээлийг ихэсгэх замаар санхүүгийн тусламжийг нэмэгдүүлэх, 2001 онд Хятадын засгийн газраас “Баруун бүс нутгийг нээн хөгжүүлэхэд чиглэгдсэн зарим арга хэмжээний тухай захирамж”-нд 18 чиглэлээр 68 хөнгөлөлттэй төсөл хэрэгжихээр заасан байна. СУӨЗО-ы засгийн газар нь тус баримт дээр үндэслэн “СУӨЗО-ы зүгээс баруун бүс нутагт үзүүлэх татварын хөнгөлөлтийн талаархи үзэл баримтлал” гэсэн баримтыг гаргаж улмаар гадаадын хөрөнгө оруулалт, нийгмийн бодлого, байгаль орчны хамгаалалт, тэргүүлэх чиглэлийн болон өндөр технологийн чиглэлийн дотоодын үйлдвэрлэлд татварын хөнгөлөлт үзүүлэхээр болов.⁵

Синьцзяны бүтээн босголтонд “Синьцзяны үйлдвэрлэл бүтээн байгуулалтын корпус” хэмээх байгууллага асар их үүрэг гүйцэтгэдэг байна. Хятадын засгийн газрын шууд мэдэлд байдаг хагас цэрэгжсэн энэхүү нэгтгэл нь цэрэг, улс төр, эдийн засгийн аргаар Синьцзян дахь тогтвортой байдлыг хангах чухал хүчин зүйл нь болж байдаг байна. Синьцзяны корпус хэмээх алдартай энэхүү байгууллага нь 14 салбартай, 174 тариалангийн газартай, мал аж ахуйн фермтэй, барилга, тээвэр зэргийн 4391 үйлдвэртэй, шинжлэх ухаан, боловсрол, соёл урлаг, эрүүл мэнд, спорт, санхүү зээлийн салбартай, нийт 2.45 сая ажилтантай ажээ. Энэхүү корпус нь 1954 онд Хятадын засгийн газраас Синьцзян дахь цэргийн хүчийг бүтээн байгуулалтын ажил эрхлэхийн зэрэгцээ хязгаар нутгийн амгалан байдлыг хамгаалах үүрэг бүхий нэгтгэл болгож зохион байгуулснаас үүдэлтэй юм. 2001 оноос энэхүү нэгтгэл нь элсэн цөл газар усжуулалтын системийг шинээр байгуулж, ойжуулах, салхи элсний нүүдлээс хамгаалах ажлыг өргөн цар хүрээтэй явуулж 1.06 сая га газар баян бүрд байгуулж Шихэцзы, Уцзяоцю зэрэг шинэ хот суурин байгуулсан нь тус өөртөө засах орны

үндэсний нийт орлогын 13.2%-ийг эзэлжээ. Синьцзяны корпус нь орон нутагт татвар төлдөг бөгөөд гол зорилго нь орон нутгийн бүтээн босголтонд хувь нэмэр оруулахад тус дэм болоход чиглэгддэг ажээ.

Ийнхүү СУӨЗО-нд өрнөх бүтээн босголт нь өргөн цар хүрээтэй төлөвлөгдөж байгаа бөгөөд энэхүү ажлыг хэрэгжүүлэхэд маш их хэмжээний мэргэжилтэн боловсон хүчин шаардагдаж байгаа юм. Хятадын засгийн газраас боловсон хүчний асуудлыг хоёр замаар шийдвэрлэж байгаа ба нэгдүгээрт үндэсний боловсон хүчнийг маш богино хугацаанд бэлтгэх нөгөөтэйгүүр Хятадын бусад нутгаас инженер техникийн ажилтныг их хэмжээгээр оруулж ирүүлэх бодлогыг баримталж байна. 1989 оноос эхлэн Хятадын засгийн газрын дэмжлэгтэйгээр их, дээд сургууль болон коллежид 10.000 оюутан 640 магистр, 860 гаруй албан хаагч, бизнесийн чиглэлээр 1.400 мэргэжилтэн тус тус бэлтгэгджээ. 2000 оноос эхлэн Бээжин, Шанхай, Тяньцзинь, Шэньчжэн зэрэг хөгжилтэй 12 хот, мужуудад Синьцзяны боловсон хүчин бэлтгэх сургалт зохион явуулж байна. Үүнээс гадна мужийн тэтгэлгээр жил бүр 1.540 уйгур болон бусад үндэстний оюутнуудыг бэлтгэн гаргаж байгаа юм. Олон тооны инженер техникийн ажилтнууд Хятадын 20 гаруй муж хотуудаас тус бүс нутгийн бүтээн босголтонд туслалцаа үзүүлэхээр томилогдон ирж байгаа ажээ. СУӨЗО байгуулагдсанаас хойш 800000 хятад иргэд тус нутагт шилжин ирсэн байна.

Хятадын засгийн газраас СУӨЗО-нд ийнхүү санхүүгийн болон ажлын хүчний хөрөнгө оруулалт хийж байгаа нь тус өөртөө засах орны хөгжлийн асуудал Хятад улсын хувьд стратегийн маш их ач холбогдолтойг харуулж байгаа юм.

АШИГЛАСАН НОМ ЗОХИОЛ

1. Хуан Жун-гюэ. Терроризм болон терроризмын эсрэг үйлдлийн хоорондын уялдаа холбоо ба түүний диалектик. Чжунгун яньцзю 2003, №1, 21-р тал.
2. Сюэ Цзунчжэн. Синьцзян: этнографический очерк. Пекин 2001. 79-р тал
3. Ма Пинь Ян. Синьцзян дахь шашны урсгалууд. Бээжин 2001, 42-р тал.
4. Мөн тэнд. 46-р тал
5. Beijing review. June 12, 2003